



## ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД, ЦААШДЫН ЗОРИЛТ

Барилга, хот байгуулалтын яамны  
Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын  
хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч

Д.ЭНХБААТАР

2024.05.04

## АГУУЛГА

- 1 ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО
- 2 ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР
- 3 ТУЛГАМДСАН АСУУДЛУУД
- 4 ЦААШДЫН ЗОРИЛТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 52

Төрийн ордон, Улаанбаатар хот

### "АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ыг 1 дүгээр хавсралтаар, ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-г 2 дугаар хавсралтаар, ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-г 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн дараагийн үе шатны хүрэх үр дүнтэй нийцүүлэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг боловсруулж, Монгол Улсын Их Хурлаар батлуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай:

1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох;

3/Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас баталсан дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэх арга хэмжээг авах;

4/"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцад 5 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Бямбацогт/-нд даалгасугай.

5."Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд нь агуулгаараа ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад тусгагдсан тул "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэ тогтоолыг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

# ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 106

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн суурийг тэлэх, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөгжлийн төслийн жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтыг 4 дүгээр хавсралтаар, Монгол Улсын Их Хуралд 2022 онд үе шаттайгаар өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2."Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг улс болон орон нутгийн төсөв, бусад санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан төр-хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулагчдын идэвхтэй оролцоонд тулгуурлан зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д тус тус даалгасугай.

3."Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4."Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилтын хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх Хөгжлийн төслийн жагсаалтад тусгагдаагүй бусад төслийг дэмжиж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 23

Төрийн ордон, Улаанбаатар хот

#### МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг 1 дүгээр хавсралтаар, Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний болон техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт бүхий Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тухайн жилийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /УХүрэлсүх/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Л.Энх-Амгалан/-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

# ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА

ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

2020 оны 12 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 203

Улаанбаатар хот

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16.3, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 1 дүгээр хавсралт, "Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
- Төлөвлөгөөнд заасан арга хэмжээг жил бүрийн улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн хүрээний мэдэгдэл, жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусган хэрэгжүүлж, ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан) нарт даалгасугай.
- Эрхлэх асуудлын хүрээнд болон харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
- Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД УХҮРЭЛСҮХ

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ





**Зорилго 6**  
Хүн бүрд ус, ариун цэврийн байгууламжийг хүртээмжтэй хүргэж, тэдгээрийн тогтвортой менежментийг хангах



- ❖ Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг шинэчилж өргөтгөн хүн амын 90-ээс доошгүй хувийг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангана.

- ❖ Ариун цэврийн байгууламжийн чанар, хүртээмжийг сайжруулж, хүн амын 90-ээс доошгүй хувийг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангана.



- ❖ Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлсэн байна.

- ❖ Ус дахин ашиглах хэмнэлттэй хэрэглэх тогтолцоог бүрдүүлсэн байна.

- ❖ Усны нөөц, ундны усны баталгаат эх үүсвэрээр хангаж, гадаргын усыг хуримтлуулан, дахин ашиглаж, усны үнэ цэнийг нэмэгдүүлнэ.

- ❖ Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн бохирдол үүсгэгчийг багасгаж, агаар, хөрс болон орчны бохирдлыг бууруулсан байна.

# ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид



Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд хоногт дунджаар 486 мян.м<sup>3</sup> усыг олборлон унд ахуйн хэрэгцээнд түгээж, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж цэвэрлэж, ус хангамжийн 3,772 км, бохир усны 1,875 км шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллаж байна.



Нийтийн зориулалттай орон сууцны байшин

8007



Нийтийн зориулалттай орон сууцны байшинд амьдарч буй айл өрх тоо

264,300



Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатны тоо

5100



Орон сууцны ашиглалт үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй байгууллага

122



Хангагч байгууллагын хүний нөөц

10,500



Сууц өмчлөгчдийн холбоо

1,625



Сууц өмчлөгчдийн холбоо хүний нөөц

7,000



Өргөх байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй байгууллага

171



## ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР



Салбарын дундаж цалин

**1,7 сая.төг**

АХБ-ны техник туслалцааны төслийн хүрээнд Нийтийн аж ахуйн байгууллагуудын хүний нөөцийг сургах, чадамжид суурилсан 20 модуль бүхий сургалтын дунд хугацааны хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Хөтөлбөрийн төслийн дагуу туршилтын сургалтуудыг зохион байгуулж давхардсан тоогоор 600 гаруй хүн хамрагдсан.

Мөн төслийн хүрээнд ХСУХАТАҮЗХ-ны сургалтын төвийг “Сургалт, судалгаа, мэдээллийн төв” болгон тохижуулж 2021 онд ашиглалтад оруулсан. Сургалтын төвд компьютер, сургалтын хэрэглэгдэхүүн самбар, дэлгэц зэрэг сургалтад ашиглах хэрэглэгдэхүүнийг нийлүүлж, 1 жилийн сургалтын төлөвлөгөөг боловсруулсан.

ШУТИС-тай хамтарч Ус хангамж, ус цэвэрлэгээ мэргэжлээр баклаврын зэрэгтэй инженер бэлтгэх цагийн эчнээ ангийг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн 28 оюутан элсэн суралцсан бол 2022-2023 онд 17, 2023-2024 онд 20 оюутан суралцаж байна.

“Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2023-2025 оны хамтын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөг батлуулсан. Салбарын ажилчдын нийгмийн баталгааг хангах, цалин хөлс, урамшуулалын жишиг журмыг боловсруулах, хөдөлмөрийн эрүүл ахуйн салбар хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах зэрэг 30 арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Салбарын инженер техникийн ажилтнуудыг гадаад, дотоодын богино хугацааны сургалтуудад хамруулсан. Тухайлбал БНХАУ, БНСУ, Япон зэрэг өндөр хөгжилтэй орнуудад ухаалаг ус хангамж, бохир ус цэвэрлэх байгууламжийн чиглэлээр 7-30 хоногийн сургалтад хамруулсан.





# ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

## Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ

				сая.төг				
XII	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД			344,981.00				
XII.1	I. Барилга байгууламж							
	Шилжих							
XII.1.2	Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2013	2025	100				
XII.1.3	Сумын төвийн шинэчлэл /Хэнтий, Биндэр сум/	2014	2024	441.5				
XII.1.4	Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г. д	2014	2025	8,000.00				
XII.1.5	Нийслэл, аймгийн төвүүдийн инженерийн	2018	2025	363.1				
XII.1.6	Нийслэл, аймгийн төвүүдийн үерийн	2018	2024	80.5				
XII.1.8	Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн систем /Улаанбаатар, Хан-Уул	2019	2024	4,010.80				
XII.1.11	Ундны цэвэр усны шугам, 2.5 км /Хөвсгөл, Цагаан-Уул сум/	2020	2024	604.8				
XII.1.12	Ус зайлуулах суваг, шугам /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Нарны хороолол, Дулаан-Уул сум/	2020	2024	81.9				
XII.1.13	Үерийн далан /Хэнтий, Цэнхэрмандал сум/	2020	2024	65.5				
XII.1.14	Үерийн усны хамгаалалтын далан суваг /Баян-Өлгий, Өлгий сум/	2020	2025	4,557.10				
XII.1.16	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр	2021	2024	4,194.10				
XII.1.17	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	2021	2024	253				
XII.1.18	Инженерийн шугам сүлжээ бүхий гэр хорооллын төсөл /Хөвсгөл, Мөрөн сум/	2021	2025	6,590.10				
XII.1.21	Сумын төвийн тохижилт /Увс, Улаангом сум/	2021	2024	104.8				
XII.1.22	Сумын төвийн цэвэр усны шугам /Өвөрхангай, Төгрөг сум/	2021	2024	351.9				
XII.1.23	Ухаалаг худаг бүхий нийтийн халуун усны барилга /Увс, Зүүнхангай сум/	2021	2024	37				
XII.1.24	Чингис хотын бохир усны төв коллекторын шугамын шинэчлэл, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/	2021	2024	6,910.20				
XII.1.26	"Залуус-1" орон сууцны хорооллын төслийн гадна инженерийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээ, барилга байгууламж, авто зам /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2022	2025	12,731.80				
XII.1.27	Аймгийн төвийн 1800 айлын орон сууцны хорооллын цахилгаан хангамж, инженерийн	2022	2025	5,120.30				
XII.1.27	Аймгийн төвийн 1800 айлын орон сууцны хорооллын цахилгаан хангамж, инженерийн							
XII.1.28	Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/	2022	2025	5,500.00				
XII.1.29	Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	2022	2024	1,000.00				
XII.1.30	Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц /Улсын хэмжээнд/	2022	2025	42,710.40				
XII.1.32	Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны шинэчлэл /Улаанбаатар, Налайх дүүрэг, 2 дугаар хороо/	2022	2025	2,500.00				
XII.1.34	Буянт Ухаа-2 хороолол орчмын ариутгах татуургын гол шугамын 2 дугаар ээлжийн ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2022	2024	790.9				
XII.1.36	Гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболт /Говь-Алтай, Есөнбулаг сум, Индэрт баг/	2022	2025	1,091.30				
XII.1.37	Гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболт /Говь-Алтай, Есөнбулаг сум, Харзат баг/	2022	2025	1,813.50				
XII.1.38	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/	2022	2024	27,262.50				
XII.1.39	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	2022	2024	16,502.70				
XII.1.40	Гэр хорооллын цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил /Хөвсгөл, Мөрөн сум/	2022	2025	4,085.50				
XII.1.41	Жишиг сум /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2022	2024	1,379.00				
XII.1.47	Орон сууцжуулах төслийн дэд бүтэц /Баянхонгор, Баацагаан сум/	2022	2025	2,686.60				
XII.1.48	Орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ /Төв, Зүүнмод сум/	2022	2024	1,834.30				



# ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

Шинэ Хархорум хот байгуулах төсөл



“Шинэ Зуунмод хот”-ын бүтээн байгуулалтын  
эхний ээлжийн бүтээн байгуулалтын төсөл



Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх  
хөтөлбөр



Улаанбаатар хотын төв цэвэрлэх  
байгууламжийг шинээр барих төсөл



Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийн  
өргөтгөл шинэчлэлтийн төсөл



Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг  
өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур  
нэвтрүүлэх төсөл







БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

# ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

“сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээ


## Төслийн ерөнхий мэдээлэл:

Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсөв
Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:	БХБЯ
Гүйцэтгэгч:	"Бурхант хясаат" ХХК
Төслийн өртөг:	8,608.2 сая.төг
Зохиогч:	"Сонголт дизайн" ХХК
Төслийн хугацаа:	2022.04.14–2025.08.30
Төслийн хэрэгжилт:	65%

## Төслийн төлөвлөлт, хүчин чадал:

№	Нэр	Үзүүлэлт	2022-2023	2024	2025
1	Халаалтын зуух	2мВт			100%
2	Усан сан	60м3	100%		
3	Цэвэрлэх байгууламж барилга	50м3	100%		
4	Дулааны шугам сүлжээ	3,019м	280м	2,739м	
5	Цэвэр усны шугам сүлжээ	3,958м	280м	2,739м	939м
6	Халуун усны барилга	79,8м2			100%
7	Ариутгах татуургын шугам сүлжээ	1,936м	1936.5		
8	Зам /асфалт/, зогсоол	7,000м2	100%		
9	Халуун ус, зуухны барилга гадна цахилгаан	207м, 768м	Зуух 100%		Халуун ус 100%

## Архангай аймаг, Ихтамир сум





1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн **8.1.4-т** “ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тухайн чиглэлээр мэргэшсэн хүнийг хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн томилж, чөлөөлөх” гэж Аймаг, сум, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд заасан заалтын хэрэгжилт хангалтгүй.



2. Хүний нөөц хомсдолтой.



3. Салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, нормативын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллахгүй байна.



4. Хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтээс шалтгаалж, төсөл, арга хэмжээ цаг хугацаандаа хэрэгждэггүй, удааширдаг, гүйцэтгэгчид үнийн өсөлтөд өртөж, гэрээний үнэ нэмэгдэх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж, байна.



01

Салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх;



02

Салбарын ажилтан, ажиллагсдын нийгмийн асуудалд онцгой анхаарч, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ажиллагсдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;



03

Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудад төрөөс дэмжлэг татаас үзүүлэх, ялангуяа нийгмийн даатгал, татварын хөнгөлөлт үзүүлэх боломжийг судлан гарц шийдлийг тодорхойлох;



04

Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нормативын баримт бичгийг шинэчлэх.





Сайн үйлс дэлгэрэх болтугай.